



**НИЙСЛЭЛИЙН
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/77

Улаанбаатар хот

Түгээмэл тархацтай ашигт малтмалын үйл ажиллагаанд хяналт хийх ажлын хэсэг байгуулах, тээвэрлэлтийг түр хугацаагаар хориглох, хяналт шалгалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "л", дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5, 12.1.8, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.4, Авто тээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2008 оны 191 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус дүүргийн 10,12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй, нөөц ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын хүнд даацын автомашины тээвэрлэлтэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй, нөөц ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын хүнд даацын автомашиныг 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд авто болон шороон замаар тээвэрлэлт хийхийг хориглосугай.

3. Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар холбогдох арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлуулах саналыг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /Г.Батсайхан/-д Мэргэжлийн хяналтын хэлтэс /Б.Алтантуяа/-т, Тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс /Ц.Бат-Эрдэнэ/-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтийг хангахад хяналт шалгалт хийх, ажлын явцад зөрчил гаргасан машинуудыг журамлан саатуулах хашааны бэлэн байдлыг хангах, Замын тэмдэг тэмдэглэгээ хийх, суудлын автомашины орох гарах гарц хийх, эвдэрсэн газрын хэмжилт хийх багаж төхөөрөмж авах, камержуулалт хийх, зөрчлийг баримтжуулах дрон худалдан авах, ажлын зардлын төсвийг хийж батлуулах, шаардагдах зардал, хяналтын цэгт томилогдсон цагдаагийн хэлтсийн албан хаагчдад олгох урамшууллыг байгаль хамгаалах, тоосжилтыг бууруулах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар /Б.Энхболд/-т, Санхүү төрийн сангийн хэлтэс /М.Цогзолмаа/-т тус тус зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн дарга /Г.Батсайханд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

Хан-Уул дүүргийн Засаг даргын
2019 оны ...03... сарын
11...-ны өдрийн ...А.Т.Т...
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга

Г.Батсайхан
Засаг даргын орлогч

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

М.Цогзолмаа
Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Алтантуяа
Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

Д.Ган-Эрдэнэ
Газрын албаны дарга

Н.Хангарьд
Замын цагдаагийн хэлтсийн дарга

Н.Батбаяр
Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн дарга

Г.Бат
Мэргэжлийн хяналтын Байгаль орчны Улсын байцаагч

Б.Ганболд
Геологи, уул уурхайн хяналтын Улсын байцаагч

Д.Батсайхан
Нийслэлийн Байгаль орчны газрын улсын байцаагч

10, 12, 13, 14 дүгээр хороодын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга

Ч.Ишдулам
Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн Байгаль орчин,
агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн